

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД БОЛОН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР
2017 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Дундговь аймгийн Засаг даргын хооронд
2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр
байгуулсан 17-010 тоот гэрээний
нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2017.12.12

Мандалговь хот

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь	Зардал /мянга н төгрөг/
1	Аймагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг улирлын онцлогтой уялдуулан сурталчилах, олон нийтийн байгаль орчноо хамгаалах уламжлалт дадлыг сэргээх.	Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг Ард телевиз, Мандалговь хотын мэдээллийн төв дэлгэцээр байгаль хамгаалах, бүх нийтээр мод тарих, аргачлал, шторкыг бэлтгэн явуулж, АС цогцолбор 31, фэйсбүүк хуудас, группээр үйл ажиллагаагаа тогтмол сурталчлан ажиллаж байна. Өндөршил, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрцогт сумд, Сайнцагаан сумын Айраг, Мандал, Нарлаг, Арвижих багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдэд байгаль хамгаалах талаар мэдээлэл өгч, 1250 ширхэг гарын авлага тараан ажиллалаа. Хавар, Намар “Нээлттэй хаалганы өдөр”, “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр тус тус иргэдийн дунд салбары хуулийг сурталчлах асуулт хариултын тэмцээн зохион байгуулж, амжилттай оролцсон иргэдийг урамшуулав. Мөн “ITM-2017” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр нийт 11000 гаруй брошур танилцуулга тараан аймаг орон нутгаа сурталчилан ажиллалаа. Аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 500 ширхгийг хэвлүүлэн жуулчны баазуудтай гэрээ байгуулсан аялал жуулчлалын компаниудад, аймгуудийн аялал жуулчлалын газрууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувь хүмүүсийг мэдээллээр хангах зорилготой үнэгүй тараасан.	100	3 078.4
		Сайхан-Овоо сумын “Ширээгийн булаг”, Хулд сумын “Булагхайрхан	100	7 500.0

2	Булгийн эхийг хашиж хамгаалах 3 булаг	булаг", Дэлгэрцогт сумын "Талын булаг"-ийн эхийг тус бүр хашиж хамгаалж, тохижуулсан. Хашиж хамгаалсан ажлыг газрын даргын 2017 оны А/26 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэлийн тайланг үндэслэн актаар хүлээн авав.		
3	Аймгийн 15 сум тус бүрт 1 усны сан бүхий газар, булаг шанд, рашааны ундаргын эхийг тэмдэгжүүлэх	Төв, суурин газрын ус түгээх байр болон гадаргын усны эхэд зориулан мэдээллийн самбарыг 15 суманд байршуулав.	100	2 250.0
4	Ойн зурвас байгуулах 10 га	Гурвансайхан, Дэрэн, Сайхан-Овоо, Сайнцагаан сумдын нутагт шинээр 10 га талбайд ойн зурвас байгуулж, усалгаа арчилгааг хийлгэн аймгийн Засаг даргын 2017 оны А/306 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь шалгаж 80,0-81,3 хувийн амьдралттайгаар хүлээж авлаа.	100	20 000.0
	Гэрээний 1 дүгээр хавсралтийн дундаж		100	32 828.4

2017 оны 01-р сарын 06-ны өдөр байгуулсан
 “Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг
 Орон нутагт хэрэгжүүлэх тухай “№ 17-010
 тоот гэрээний хоёрдугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ
 МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
 САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД**

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1	<u>1. Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:</u> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан орлогоос тухайн аймагт 2017 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарилагдсан мөнгөн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэх	2017 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд нийт 32828400 /Гучин хоёр сая найман зуун хорин найман мянга дөрвөн зуун/ төгрөг батлагдсан. Үүнээс: 1. Аймагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг улирлын онцлогтой уялдуулан сурталчлах, олон нийтийн байгаль орчноо хамгаалах уламжлалт дадлыг сэргээхэд 3 078 400 төгрөг. 2. 3 булгийн эхийг хашиж хамгаалахад 7 500 000 төгрөг зарцуулсан. 3. 15 сумдад төв, суурин газрын уст цэг болон гадаргын усны эхийг тэмдэгжүүлэхэд зориулж 2 250 000 төгрөг зарцуулсан. 4. 10 га талбайг ойжуулахад 20 000 000 төгрөгийг тус тус зарцуулсан.	100
2	Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор хяналт шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн гаргаж ирүүлэх	Байгууллагын 2017 оны төлөвлөгөөний 1.2, 1.3, 7.1, 7.2 дахь заалтаар хяналт шалгалтын ажил зохион байгуулахаар төлөвлөн ажилласан. Төлөвлөгөөний хүрээнд аймгийн МХГазартай хамтран ангийн эргүүл, уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй ААНэгжийн үйл ажиллагаа болон бичил уурхай, ШТСтанц, Төв суурингийн халаалалтын зуух зэрэг газруудад хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгээд байна. Шалгалтаар илэрсэн зөрчил бүрт МХГ-аас үүрэг даалгавар өгч гүйцэтгэлийг хангуулан ажиллав. Хяналт шалгалт бүрийг илтгэх хуудас, фото зургаар тайлагнав.	100
3	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангахад салбарын ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулах, ажлын байр, бие хамгаалах хэрэгсэл бусад	Тус байгууллага нь албан хаагчдын нийгмийн баталгаа, сурах нөхцлийг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулан, төлөвлөгөө батлан ажиллаж байна. Дээрх бодлогын хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай заал, танхим, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин техникээр 100 хувь ханган ажиллаж байна. Байгаль хамгаалагчдад бие	100

	шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	хамгаалах хэрэгсэлд цахилгаан бороохой гав, хийн гар буу байгаагаас гадна 2 нүдний дуран, энгэрийн камер 2 ширхэг олгосон. Мөн бүх байгаль хамгаалагчид мотоциклтой бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5 байгаль хамгаалагчид мотоциклыг шинэчлэн өгсөн. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 3.3 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 10.0 сая төгрөг нийт 13.3 сая төгрөг зарцуулсан.	
4	Мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг байгаль хамгаалах чиглэлээр сургалтанд хамруулах, үйл ажиллагаа, тухайн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтэнд үнэлэлт дүгнэлт өгөх.	<i>Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлага, мэргэжилтнүүд:</i> “Удирдах ажилтнуудын зөвөлгөөн”, “Ойн хамгаалал ойн нөхөн сэргээлтийн мэдээллийн сан”, “Газар загас, ойн нөөцийн эдэлбэр газрын засаглалын сайн дурын зөвлөмж бүсийн сургалт”, “Сав газрын захиргаадын хамтын оролцоо менежмент”, “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний чуулган”, “Бичил уул уурхайн эрхзүйн орчин” зэрэг 12 удаагийн сургалтанд оролцов. <i>Сумдын байгаль орчны мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нар:</i> “БОАЖГазрын 2016 оны ажлын үр дүн, 2017 оны хийгдэх ажлын талаар сургалт”, “Сав газрын зөвлөлийн 3,4-р чуулган”, “Монгол орны цөлжилтийн эсрэг ойжуулалт”, “Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол” зэрэг 5 удаагийн сургалтанд хамрагдсан.	100
5	ТББ, Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг чадавхижуулах нэгтгэн зохион байгуулах, үйл ажиллагаанд хамтран дэмжлэг үзүүлэх.	“Эко-Үйлчилгээ” ТББ, Гурвансайхан, Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Адаацаг сумдад 20 өрхийн 40 гаруй гишүүдтэй агнуурын бүс хариуцсан нөхөрлөл байгуулагдсан. Дээрх нөхөрлөлүүд нь байгаль хамгаалах нөөц баялгийг зохистой ашиглах үйл ажиллагааг хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс гадна нөхөрлөлийн үйл ажиллагаа, санхүүжилтийн гэрээг дээрх сумдын Засаг дарга нартай байгуулж, байгаль хамгаалах үйл ажиллагааг нутгийн иргэдээр гүйцэтгүүлэх, БО-ны эсрэг гэмт хэргийг шуурхай илрүүлэх зэрэг чиглэлийг баримтлан хэрэгжилтийг хангаж байна. Одоогийн байдлаар аргал хонь, янгир ямаа, тарвага, чоно, үнэг, цагаан зээр, хар сүүлт, ятуу зэрэг амьтдын талаарх мэдээлэл, судалгааг гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. БНСУлсын санхүүжилтээр “Ногоон–Ази” ТББ-тай хамтран 10 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг 9 дэх жилдээ гүйцэтгэж байгаа бөгөөд энэ онд нийтдээ 13000 ширхэг суулгац тарьж ургуулах ажлыг гүйцэтгээд байна.	100
6	Аймгийн Засаг даргын зөвлөлийн	Аймгийн Засаг даргад зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах талаар саналыг	

	бүрэлдэхүүнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөллийг оруулах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэст газрын даргын 2017 оны 1/139 тоот албан бичгээр хүргүүлсэн.	0
7	2015 онд бэлтгэгдсэн Насан туршийн боловсролын төвийн сургагч багш нараар дамжуулан аймгийн хэмжээнд Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн асуудлаар олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулах ажлыг хамтран хэрэгжүүлэх	“Тогтвортой хөгжлийн боловсрол сургалт”-ыг Байгаль хамгаалах боловсролын төв ТББайгууллагаас Боловсрол соёл, урлагийн газартай хамтран ЭДЦС, Мандал сургууль, Луус, Эрдэнэдалай сумын ЕБСургуулийн 50 гаруй багш сурагчдад сургалт зохион байгуулав.	100
8	Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах зан үйлийг хэвшүүлж, байгальд ээлтэй сургуулиудыг бий болгох болзолт уралдаан зарлах	БОАЖЯам, БСШУСЯам, Байгаль орчны мэдээлэл сургалтын төвийн хамтран хэрэгжүүлсэн “ЭКО СУРГУУЛЬ ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ 3-Р ЧУУЛГА”-нд Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургууль, Мандал сургууль, Эрдэнэдалай сумын ЕБСургуулийн төлөөлөл болон аймгийн БСУГазрын удирдлагын хамт 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцов. Чуулганаар улсын тэргүүний Мөнгө, Хүрэл гэрэгэ болон Эко сургууль хөтөлбөрийн Ногоон тугийн эздийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлав.	70
9	<u>2. Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр</u> Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах	Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Гурвансайхан, Дэлгэрцогт, Адаацаг, Сайнцагаан сумдын улсын болон аймгийн Тусгай хамгаалалттай газарт идээшлэн амьдардаг ховор амьтдад биотехникийн арга хэмжээг цаг үеийн байдалтай уялдуулан хэрэгжүүлж байна. Биотехникийн арга хэмжээг сумдын БОХНСАХэмжээний зардлаас нөхөрлөлийн гишүүдийн дэмжлэгтэйгээр нийт 3 сая орчим төгрөгний ажлыг гүйцэтгэв.	100
10	Тарваганы тооллого явуулж тайлан, мэдээ ирүүлэх	БО-ны мэргэжлийн байгууллага болох “Эко-Үйлчилгээ” ТББайгууллагатай гэрээ байгуулан тооллого, судалгааг гүйцэтгэж тайланг БОАЖЯаманд албан тоотоор хүргүүлэв. БО-ны мэргэжлийн байгууллага болох “Эко-Үйлчилгээ” ТББайгууллагатай гэрээ байгуулан тооллого, судалгааг гүйцэтгэж тайланг БОАЖЯаманд албан тоотоор хүргүүлэв. Уг зүйлийг тусгайлан тоолж байгаагүй бөгөөд энэ удаагийн судалгаагаар нийт 39 бүлийн 206 бодгал бүртгэгдсэн байна.	100
11	Тухайн аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар агнасан амьтны тоо толгойн гүйцэтгэл, орон нутагт орсон орлого зэргийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн	Аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар 30, ахуйн зориулалтаар 100 толгой ангийн зөвшөөрөл олгогдсон. 2017 онд 246,3 сая төгрөгний орлогыг орон нутагт төвлөрүүлж, тайланг БОАЖЯаманд хүргүүлэв.	100

	буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт ирүүлэх		
12	Байгалийн ургамал ашиглах хэлбэрүүдийг тогтоох суурь судалгаа авах	Газрын даргын 2017 оны 1/102 тоот албан бичиг сумдад явуулж тухайн нутаг дэвсгэрийнхээ ургамлын төрөл зүйлийг судлан тогтоох суурь судалгааг авч нэгтгэв. Судалгаагаар нэн ховор-5, ховор-5, эмийн-22, бэлчээрийн-53 төрөл зүйлийн ургамал бүртгэгдсэн.	100
13	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх,	Байгалийн нөөц ашигласны төлбөрын тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолын хүрээнд эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр төсөв батлагдаагүй байгаа хэдий ч сумдын Засаг дарга нарт чиглэл өгч, гэрээнд нь тусгаад байна. Эвдэрч эзэнгүй орхигдсон газрын тооллого судалгааг 2018 онд аймгийн хэмжээнд шинэчлэн гаргахаар төлөвлөн ажиллаж байна.	30
14	Нөхөн сэргээлт хийх нэртэй ашиглалт хийх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийг илрүүлж зогсоох арга хэмжээг авах.	Одоогийн байдлаар бүртгэгдээгүй байна.	100
15	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулахдаа булаг шандыг хамгаалах, мод тарих, ногоон байгууламж бий болгох, байгаль орчныг хамгаалах ажлуудыг тусгах.	2017 оны 05 сарын 05-нд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНэгжийн зөвлөлдөх уулзалтанд хамтран ажиллах гэрээний төсөл танилцуулж, байгаль орчныг хамгаалах ажлуудыг нэг бүрчлэн оруулав. Мөн 2017 оны БОМТөлөвлөгөөнд булаг шандыг хамгаалах, мод тарих, ногоон байгууламж бий болгох, байгаль орчныг хамгаалах ажлуудыг төлөвлөж, БОАЖЯамаар батлуулан хэрэгжүүлдэг. 2017 онд ашиглалтын төлөвлөгөөний дагуу ажилласан “МАК” ХХК-ны Дэлгэрхангай сумын гөлтгөнө, Баянжаргалан сумын нүүрсний орд, “Тайшэндевелопмент” ХХК, Говь-Угтаал сумын “Чинхаш” ХХК зэрэг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААНэгжүүдын БОМТөлөвлөгөөг 11-р сарын 29-ны өдрөөс 12-р сарын 09 хооронд газар дээр нь хүлээн авч үнэлгээг гаргав. Дунджаар 80 хувьтай үнэлэгдсэн байна. Нийт 710 мод тарьж, 1 булгийг сэргээн тохижуулсан байна.	100
16	<u>3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр</u> Ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс 2016 онд 11,3 сая төгрөгийн орлого орсон. Үүний 35 хувь нь 4 сая төгрөг болно\ Рашааны хамгаалалтын бүсийн	2016 оны усны нэгдсэн тоо бүртгэл, Рашааны хамгаалалтын дэглэмийг мөрдөх ажлын хүрээнд Хулд сумын 4–р багийн нутагт байрлах Бүлээний рашааныг эхийг хамгаалахад 2,5 сая төгрөгний санхүүжилт батлуулж, хэрэгжүүлэв. “Майн ланд майнинг” ХХКомпани гүйцэтгэсэн. Орон нутаг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 3 булгийн эхийг хашиж хамгаалахад 7 500 000 төгрөг, 15 сумдад төв, суурин газрын уст цэг болон гадаргын усны эхийг тэмдэгжүүлэхэд	100

	дэглэмийг мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх	зориулж 2 250 000 төгрөг нийт 9 750 000 төгрөг зарцуулсан.	
17	Хаврын шар усны, зуны хур борооны үерийн илүүдэл усыг хуримтлуулах хөв цөөрмийг байгуулж, гадаргын усыг хуримтлуулах замаар малын ус хангамжийг шийдвэрлэх, экосистемийн таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	УЦУОШГазар болон сумдын ЗДТГазраас өгсөн мэдээллээр сүүлийн 10 жилийн хугацаанд орсон хур тунадасны хэмжээгээр хөв цөөрөм байгуулах хэмжээний усан хуримтлал үүсэх нь ховор бөгөөд улсын төсвөөс хөрөнгө гарган тус байгууламжийг байгуулахад үр ашиг багатай. Харин энэ оны 7-р сард орсон борооны улмаас бэлчээрт тогтоол ус бий болж, мал, амьтдын ундаалах боломж нэмэгдсэн. Цаашид Байгалийн нөөцийн хамтын менежмент болон усны менежментийн хүрээнд зэрлэг амьтанд зориулсан уст цэгийг байгуулахаар төлөвлөөд байна.	100
18	Гадаргын усны тоо бүртгэл болон ус бохирдуулагчийн тоо тооллогыг сав газрын захиргаатай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах	Гадаргын ус болон энгийн уурхайн худаг, гүн өрмийн худгийн тоо бүртгэлийг аймгийн хэмжээнд гаргаж мэдээллийн санд оруулж, БОАЖГазрын 1/114 албан тоотоор БОАЖЯам руу хүргүүлсэн. Тооллогоор Булаг-119, рашаан-4, худаг-3343 /энгийн уурхайн худаг-2769, гүн өрмийн худаг-574/ тоологдсон.	100
19	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, самбаржуулах хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Төв, суурин газрын ус түгээх байр болон гадаргын усны эхэд зориулан мэдээллийн самбарыг 15 суманд байршууллаа. Уст цэг болон гадаргын усны эхийг тэмдэгжүүлэхэд зориулж байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2 250 000 төгрөг зарцуулсан. “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүрийн 5, 10 дугаар саруудад сумын төвийн хүн амын унд ахуйн усны орчин, төвөөс 5-10 км-т байдаг булаг шандны эх дээрх хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлдэг. 2017 онд нийт 2,5 тн хог хаягдал цэвэрлэж төвлөрсөн цэгт хаясан байна.	100
20	Аж ахуйн нэгж, байгууллагад усны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулах	Аймгийн төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж 80, айл өрх 1200 бүрэн тоолууржуулсан. Одоогоор аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашиглаж байгаа худгуудыг бүрэн тоолууржуулсан.	100
21	Хот суурин газрын ус хангамж, гидрогелогийн зураглалын судалгаа гарган, хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг эхлүүлэх/ Усны хайгуул судалгааны ажил Сайхан-Овоо суманд/	Ус–Амьдрал” ХХК нь тус сумын усны нөөц тогтоох геофизикийн хайгуул судалгаа болон өрөмдлөгийн ажлыг хийсэн. Тус сумын төвөөс хойш Дуганатээг, сумын төвөөс урагш Сэнжит, сумын төвийн баруун тал Онги голын баруун тал зэрэг 3 газар судалгаа хайгуулын ажлыг хийсэн. Сэнжит, Дугана тээг гэдэг 2 газар өрөмдөж судалгаа хийхэд сумын төвийн усны хангамж нөөц нь бага усны чанар унданд хэрэглэхэд тааруухан гэж гарсан учир сумын төвөөс баруун тийш 2км орчим Онги голын баруун талд өрөмдсөн. Усны нөөц болон ахуйн хэрэглээнд	100

		найрлага нь тохирсон гэж тогтоогдсон тул тухайн газраас 400 метрийн зайд дахин өрөмдлөгийн ажлыг хийж 5 л/с ундаргатай усны нөөц тогтоов.	
22	4. Газар зохион байгуулалтын чиглэлээр: Голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа, элс хайрганы карьер ашиглаж буй аж ахуйн нэгж байгууллагын газрын эрхийг цуцлах арга хэмжээг авах, нүүлгэн шилжүүлэх,	Тус аймагт голын дагуу элс хайрганы карьер ашиглаж буй аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдээгүй байна.	100
23	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, ААНБ-д онцгой албан татвар ногдуулах замаар голд ойрхон газар эзэмшиж, ашиглах сонирхолыг хязгаарлах дүрэм журам гаргах, хэрэгжүүлэх	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж бүртгэгдээгүй бөгөөд цаашид Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар олгуулахгүй байх талаар анхаарч ажиллана.	100
24	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшүүлэх гэрээ байгуулах, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, газрын төлбөр ногдуулах, төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.	Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл авч, хайгуул хийж байгаа 1 ААНэгж байна. Тус ААНэгж нь 2 дахь жилдээ хайгуулын ажил хийж, төлөвлөгөөгөө батлуулан тайлагнаж байна. Газрын мэдээллийн санд хуулийн дагуу бүртгүүлэн, төлбөр тооцоо хийж байна. 2017 оны 11 сарын байдлаар орон нутгийн төсөвт түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 21.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	100
25	Өөрийн нутаг дэвсгэр дэх эзэнгүй орхигдсон бохирдож, доройтсон, эвдэрч, ухагдсан газрын тооллого, судалгааг хийн, газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу газрын төлбөрийн орлогын 15 хувийг газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах.	Гурвансайхан, Дэрэн, Сайхан-Овоо, Сайнцагаан сумдын нутагт байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 20.0 сая төгрөгний санхүүжилттэйгээр шинээр 10 га талбайд ойн зурвас байгуулж, усалгаа арчилгааг хийлгэн аймгийн Засаг даргын 2017 оны А/306 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь шалгаж 80,0-81,3 хувийн амьдралттайгаар хүлээж авсан. 2018 онд эзэнгүй орхигдсон бохирдож, доройтсон, эвдэрч, ухагдсан газрын тооллого, судалгааг хийн, газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Уг тооллого судалгааг аймгийн ГХБХБГазар, МХГазартай хамтран хэрэгжүүлэхээр захирамжийн төсөл боловсруулаад байна. аймгийн 2018 оны төсөвт тусгах саналыг хүргүүлэхээр бэлтгээд байна.	70

26	5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр: Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн санг үүсгэх	Аймгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн судалгаа, эвент арга хэмжээний талаарх мэдээллээр мэдээллийн сан бүрдүүлж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нээлттэй хаалганы өдөр, аймгийн вэб сайт, фэйсбүүк хуудас ашиглан мэдээллэж байна. Хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжид и-мэйл болон хэвлэмэл байдлаар мэдээллийг явуулж байна. Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар жуулчны бааз-9, гэст хаус-1, рашаан сувилал-2, амралтын газар-3, аймгийн төвийн зочид буудал-5 тогтмол үйл ажиллагаа явуулж байна. 2012-2017 оны жуулчдын статистик мэдээллийг гарган АС цогцолбор, аймгийн вэб сайт, МОНЦАМЭ мэдээллийн сайтуудаар тус тус мэдээллэв. 2017 онд Дундговь аймагт 13474 гадаад, дотоодын жуулчид ирсэн бөгөөд үүнээс 10421 нь гадаадын жуулчид байна. Өмнөх онтой харьцуулахад гадаадын жуулчид 32%-иар, дотоодын жуулчид 20%-иар өссөн байна. Мэдээллийг шинэчлэн БОАЖЯаманд хүргүүлэв.	100
27	Аялал жуулчлалын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдтэй хамтарч ажиллах сургалт зохион байгуулах.	Төр хувийн хэвшлийн 30 орчим төлөөлөл оролцсон “Аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр аймагт зохион байгуулагддаг арга хэмжээ /эвент/, баяр наадам зохион байгуулах хугацааг тодорхой болгох, аялал жуулчлалын газрын зургийг хэвлүүлэх, аялал жуулчлалын мэдээллийн төвийг аймгийн музейг түшиглэн ажиллуулах зэрэг салбарын хэмжээнд тулгамдсан асуудлаар санал солилцож, нэгдсэн ойлголцолд хүрч ажилласан. Уг арга хэмжээний үеэр аймгийн Засаг дарга болон “Говийн шуранхай” АЖХолбооны хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. ИГЧБЦГХЗахиргаатай "Төв боржигон Тур" ХХК-ны удирдлага болон үйлчилгээ эрхлэгчдэд "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426:2016 стандарт, Зочин угтах, үдэх үйлчилгээний талаар сургалтыг зохион байгууллаа. Аймгийн төвийн зоогийн газар, зочид буудал, үйлчилгээний газруудын ажилчдад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Сайнцагаан сумын ЗДТГ, МСҮТ, Говийн бүсийн арга зүйн төв, "Өүлэн эхийн ачлал" ХХК-тай "Зөөгч, бармен, зочид буудлын үйлчилгээний ажилтны мэргэжил олгох сургалт"-ыг 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулагдаж 20 гаруй хүн хамрагдав.	100
	Өөрийн аймгийн онцлогийг тусгасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргаж	“Зава Дамдины мэндэлсний 150 жилийн ой”, “Аймгийн баяр наадам” арга хэмжээнүүд 07 сарын 26-30 өдрүүдэд зохион байгуулагдлаа. ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр эвент арга хэмжээний	

28	сурталчлах ажлыг эхлүүлнэ	танилцуулгыг иргэдэд мэдээллэсэн. Мөн МАЖХолбооноос жил бүр гаргадаг цагалбарт оруулж сурталчилсан. “Монгол айрагны баяр-2017” эвент арга хэмжээг 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулагдахаар төлөвлөсөн ч малын гоц халдварт өвчний улмаас аймгийн Засаг даргын 2017 оны А/279 тоот захирамжаар цуцлагдсан. Ноос ноолууран эдлэл, гар урлал эрхлэгч “Цагаан суварга” компань “Улаанбаатар-2017” аялал жуулчлалын үзэсгэлэнд 06 сарын 03-04-ний өдрүүдэд бүтээгдэхүүнээ танилцуулан аймгаа төлөөлөн оролцож, борлуулалт хийв.	100
29	<u>6. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах чиглэлээр</u> Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, нөхөн сэргээх, сургалт сурталчилгаа хийх	“Их газрын чулуу” БЦГазар менежментийн төлөвлөгөөг 2015 онд БОАЖЯамны ТХНУГазраар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. “Их газрын чулуу” БЦГазарт жуулчдын отоглох газрын тохижилтыг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран хийв. Хоноглох газарт сүүдрэвч, ОО, байгалийн чулуугаар ширээ, сандал, дугуйгаар машины зогсоол, салаалсан замуудад чулуугаар хаалт зэргийг хийсэн. Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт “Олон улсын биологийн төрөл зүйлийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан орчны бүсийн 3 сумын ЕБС-ийн экоклубын сурагчдын хооронд “Эко” өдөрлөгийг амжилттай зохион байгуулж, нийт 59 хүүхэд оролцсон “Бид Их газрын чулууны БЦГ-ын байгаль хамгаалагч сурагчид” сэдэвт сургалт хүмүүжлийн арга хэмжээг зохиож, 13,7 км-т явганаар аялав.	100
30	Улсын тусгай хамгаалалттай газарт тэмдэгжүүлэлт хийх	2016 онд улс, аймгийн тусгай хамгаалалттай газар нутгуудад байгалийн боржин чулуугаар нутаг орны онцлогийг харуулсан дүрслэл бүхий, зам чиглэл заасан, шөнийн цагт гэрэлтэй байхаар төлөвлөсөн тэмдэг тэмдэглэгээ хийх төсөл хэрэгжүүлсэн бөгөөд аялал жуулчлалын төвлөрөл бий болсон бүс нутгууд болох Дэлгэрхангай, Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд сумдын 17 байршилд уг тэмдэглэгээг байршуулсан. ОНХС-аас 80 сая төгрөгийг уг төсөлд зарцуулсан.	100
31	Улсын тусгай хамгаалалттай газрын булаг шандыг хашиж хамгаалах	УТХамгаалалттай 4 газрын 3-т нь буюу Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны уулын “Өгөөмрын булаг”, Гурвансайхан сумын ИГЧБЦХГЗахиргаа “Эрээн булаг”, Дэлгэрхангайн сум Дэлгэрхангай ууланд “Гурван булаг”, “Хөөврийн булаг”, “Гуулин булаг” тус тус хашиж хамгаалсан.	100
32	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны	Дэлгэрхангай уул улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газар, Бага газрын чулуу улсын тусгай хамгаалалттай байгалийн дурсгалт	

	дагуу Байгалийн нөөц болон дурсгалт газрын хамгаалалтын горим, дэглэмийг тогтоож хамгаалалыг хэрэгжүүлэхээр заасан байдаг тул аймгийн төсөвт зардал төлөвлөж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	газар, Загийн ус улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газарт тус бүр орон тооны 7 байгаль хамгаалагч, орон тооны бус 62 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байна. Мөн тус бүс нутагт амьдардаг иргэдэд сургалт, сурталчилгааг явуулахаас гадна тооллого, судалгаа, биотехникийн арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн ажиллаж байна.	100
33	Тусгай хамгаалалттай газарт ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газруудын тусгай зөвшөөрлийг цуцлах бодлого барьж, хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацаа дууссан ААН-ийн лицензийн хугацааг үргэлжлүүлэн сунгах болон нэмж зөвшөөрөл олгохгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах;	ИГЧБЦГХЗахиргаанаас тусгай хамгаалалттай газар нутагт хилийн цэстэй давхцсан 3 ААН-ийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах талаар “Ашигт малтмал, газрын тосны газар”-т санал албан тоотоор хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна. Мөн шинээр олгогдож буй хайгуулын талбайн өргөдөлд хуулийн хүрээнд хариу хүргүүлэн ажиллаж байна.	70
34	Байгаль орчны эвдэрсэн бохирдсон газрын экологи-эдийн засгийн үнэлгээг тооцож гаргах, тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг жил болгон авч, байгаль орчны улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгэх;	Аймгийн хэмжээнд химийн бодис, мал угаалгын дуст, пестизид, диоксин ба фуранаар бохирдсон газрын судалгааг авч нэгтгэлээ. ҮүндДэлгэрцогт, Говь-Угтаал, Баянжаргалан,Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Сайнцагаан Адаацаг сумдуудаас судалгааг авч нийт мал угаалгын газар-3, төвлөрсөн хогийн цэг-10, химийн бодисийн ашиглалтаар бохирдсон-2 газрыг бүртгэлээ. 2018 онд эвдэрч эзэнгүй орхигдсон газрын тооллого, судалгааг хийхээр бэлтгэл хангаж байна.	100
35	Улсын тусгай хамгаалалттай газар дахь аялагч, жуулчдын отоглох, тохижилтыг хамтран хийх;	“Их газрын чулуу” БЦГазарт жуулчдын отоглох газрын тохижилтыг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран хийв. Хоноглох газарт сүүдрэвч, ОО, байгалийн чулуугаар ширээ, сандал, дугуйгаар машины зогсоол, салаалсан замуудад чулуугаар хаалт зэргийг хийв.	100
36	<u>7. Ойн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр</u> “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр, ойн зурвас байгуулах	Улсын төсвийн 20 сая, орон нутаг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 20 сая нийт 40 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 20 га талбайд ойжуулалт хийлгэж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь ажиллаж хүлээн авлаа. /Ургалтын хувь 80-82,5/	100
	Гэрээний 2 дугаар хавсралтийн дундаж		92.77
	Хэрэгжилтийн хувь 100 хувь – 35 70 хувь – 3 30 хувь – 1 0 хувь – 1		96.38

	мэдээллийн санд бүртгэх;	хийхээр бэлтгэл хангаж байна.	
35	Улсын тусгай хамгаалалттай газар дахь аялагч, жуулчдын отоглох, тохижилтыг хамтран хийх;	“Их газрын чулуу” БЦГазарт жуулчдын отоглох газрын тохижилтыг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран хийв. Хоноглох газарт сүүдрэвч, ОО, байгалийн чулуугаар ширээ, сандал, дугуйгаар машины зогсоол, салаалсан замуудад чулуугаар хаалт зэргийг хийв.	100
36	7. Ойн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр, ойн зурвас байгуулах	Улсын төсвийн 20 сая, орон нутаг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 20 сая нийт 40 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 20 га талбайд ойжуулалт хийлгэж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь ажиллаж хүлээн авлаа. /Ургалтын хувь 80-82,5/	100
		Гэрээний 2 дугаар хавсралтийн дундаж	92.77
		Хэрэгжилтийн хувь 100 хувь – 35 70 хувь – 3 30 хувь – 1 0 хувь – 1	93.5

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

БИЕЛӨЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ГАНТУЛГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ